



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: moh@moh.gov.mn, <http://www.moh.gov.mn>

2025.12.02 № 2/5719
танай _____-ны № _____-т

**ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Б.ГАНЗОРИГ ТАНАА**

Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/323 дугаар тушаалаар байгуулагдсан Дэд комисс тус байгууллагад "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалт"-ын улсын үзлэг явуулсан тайлан, зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана уу.

Хавсралт 23 хуудастай.

Эмгэг судлалын үндэсний төвд “Төрийн байгууллагын архив,
албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалт”-ын үйл ажиллагаанд
явуулсан улсын үзлэгийн дүнгийн тухай

Монгол Улсын Засгийн газрын “Улсын үзлэг явуулах тухай” 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 23 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Дүгнэх үзүүлэлт, аргачлал хүргүүлэх тухай” 2025 оны 3/1045 дугаартай албан тоот, Эрүүл мэндийн сайдын “Дэд комисс байгуулах тухай” 2025 оны А/323 дугаар тушаалыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга С.Эрдэнэтуяа, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн Б.Оролзодмаа, Төрийн захиргааны удирдлагын газрын Бичиг хэргийн эрхлэгч Б.Амгаланзаяа, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Архивын эрхлэгч Р.Мөнхбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Төрийн байгууллагын Архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийг Эмгэг судлалын үндэсний төв (цаашид ЭСҮТ гэнэ)-д 2025 оны 10 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд явууллаа.

Үзлэгийг явуулахад Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Монгол хэлний тухай, Цахим гарын үсгийн тухай, Нийтийн ил тод байдлын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад захиргааны хэм хэмжээний акт, удирдамжийг мөрдлөг болгосон.

Улсын үзлэгийн дэд комисс дээрх байгууллагын удирдлага, холбогдох ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, үзлэгийн явцад илэрсэн алдааг газар дээр нь засуулах дутагдалыг арилгуулах арга хэмжээ авсан болно.

Улсын үзлэгийн зорилго нь төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний зорилт чиглэлийг тодорхойлоход оршино.

Үзлэгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, байгууллагын архивын үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлт, аргачлал гэсэн 3 үндсэн чиглэлийн дагуу явуулж дүгнэв. Үүнд:

Нэг.Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаар

Төв нь Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам холбогдох дүрэм, журам, стандартын дагуу албан хэргээ хөтлөн явуулж байна. Албан хэрэг хөтлөлтийн программаар ирүүлсэн албан бичиг, дээд газрын тогтоол шийдвэрийг хүлээн авч бүртгэн удирдлагад танилцуулан шийдвэрлэлтэд хяналт тавин хугацаанд нь хариу хүргүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна.

1.1.Бичиг хэрэг, архивын ажилтны батлагдсан орон тоотой. Бичиг хэрэг, архивын ажилтны албан тушаалын тодорхойлолтод чиг үүргийг оновчтой тусгаж үнэлж хэвшсэн байна.

1.2.Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2.2.9-д заасны дагуу байгууллагын нийт ажилтны албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хэрэг хөтлөлтийн талаар хүлээх үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээг тусгаагүй, дүгнэж хэвшээгүй.

1.3.Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2.5.9-д заасны дагуу ажилтан ажлаас чөлөөлөгдөхөд бичиг хэрэг, архивын ажилтан гишүүнээр ажиллаж цаасан болон цахим баримтыг актаар хүлээж авч хэвшээгүй.

1.4.Бичиг хэрэг, архивын ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг хангах чиглэлийн хүрээнд жил бүр нийт ажилчдыг эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулж, 2020 онд НОСК-той хамтарч бичиг хэрэг, архивын ажилтанг түрээсийн орон сууцанд хамруулсан. Мөн бичиг хэрэг, архивын ажилтны үр дүнг улирал тутам, ур чадварыг сар тутамд үнэлж урамшуулал олгож хэвшсэн. Мөн нууцын ажилтанг давхар хавсран ажилладаг ба үндсэн цалингийн 20%-ын нэмэгдлийг сар бүр олгодог.

1.5.Бичиг хэрэг, архивын ажилтанг 2024.11.22-нд, 2025.09.25-нд тус тус Архивын ерөнхий газрын мэргэшүүлэх сургалтад хамруулсан.

1.6.Бичиг хэргийн ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны гэрэлтүүлгийн норматив, өрөө тасалгаа хэвийн нөхцөлтэй. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох техник хэрэгсэл, компьютер, сканнер, принтер бусад холбогдох тоног төхөөрөмжөөр хангагдсан.

1.7.Байгууллагаас гаргасан захиргааны шийдвэрийн хувийн хэргийн хөтлөлт, шийдвэр гаргах үйл ажиллагааны үндэслэл, үе шат, оролцогчийн санал холбогдох баримт сонсох ажиллагаа уулзалт хуралдааны тэмдэглэл, шийдэл, хүргүүлсэн, мэдэгдсэн баримт зэргийг архивт шилжүүлсэн.

1.8.Боловсруулж, батлан гаргасан баримт бичгийг крилл бичгээр боловсруулахдаа зөв бичих дүрэм найруулга зүйг баримтлан ажиллаж байна.

1.9.Баримт бичгийн эргэлтийн хэмжээ, мэдээ тайланг гаргаж хэвшээгүй.

1.10.Крилл болон Монгол бичгийн хэвлэмэл хуудсаа Архивын ерөнхий газрын хяналтын улсын байцаагчаар хянуулж баталгаажуулсан. Хэвлэмэл хуудсаа нэр төрөл бүрээр нь захирлын тушаалаар индексжүүлээгүй.

1.11.MNS 5140-2-2021 стандартын 5.14-ыг байгууллагын баримт бичгийг боловсруулахдаа мөрдөн ажиллаж байна.

1.12.Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулж хэвшээгүй. Бүтцийн нэгжээс санал авч хэвшээгүй.

1.13.Төвийн албан хэрэг хөтлөлтийн журмыг батлуулаагүй, албан хаагчид үйл ажиллагаандаа мөрдөж хэвшээгүй байна.

1.14.Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ABLE систем ашигладаг ба 2025 оны 06 сард нэвтрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

1.15. 4.Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ын хэрэгжилтийг хангаагүй байна.

1.16.2019 онд Улсын үзлэг ирээгүй. 2024 онд ЭМЯ-аас ирсэн урьдчилсан үзлэгийн биелэлтийг хүргүүлээгүй байна.

1.17.Бичиг хэрэг, архивын ажилтны компьютер лицензтэй программгүй, зөөврийн хардтай.

Цаашид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1.Хэвлэмэл хуудас, тамга тэмдэг хариуцсан ажилтан томилж, зарцуулалтыг тооцож хэвших, Хэвлэмэл хуудас хариуцсан ажилтан томилж, чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусгах

2.Байгууллагын нийт ажилтны албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хэрэг хөтлөлтийн талаар хүлээх үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээг тусгаж, дүгнэж хэвших.

3.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 24.1.1-д заасан үүргийг хэрэгжүүлж Бичиг хэрэг, архивын ажилтанг мэргэшүүлэх сургалтад хамруулах.

4.Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ын хэрэгжилтийг ханган ажиллах.

5.Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад санал авч батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж хэвших.

6.Албан хэрэг хөтлөлтийн журмыг байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн боловсруулж ажилчдад танилцуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.

Хоёр.Архивын үйл ажиллагааны талаар

2.1.Бичиг хэрэг, архивын ажилтны батлагдсан орон тоотой. Бичиг хэрэг, архивын ажилтны албан тушаалын тодорхойлолтод чиг үүргийг оновчтой тусгаж үнэлж хэвшсэн байна.

2.2.Бичиг хэрэг, архивын ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг хангах чиглэлийн хүрээнд жил бүр нийт ажилчдыг эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулж, 2020 онд НОСК-той хамтарч бичиг хэрэг, архивын ажилтанг түрээсийн орон сууцанд хамруулсан. Мөн бичиг хэрэг, архивын ажилтны үр дүнг улирал тутам, ур чадварыг сар тутамд үнэлж урамшуулал

олгож хэвшсэн. Мөн нууцын ажилтанг давхар хавсран ажилладаг ба үндсэн цалингийн 20%-ын нэмэгдлийг сар бүр олгодог.

2.3.Бичиг хэрэг, архивын ажилтанг 2024.11.22-нд, 22025.09.25-нд тус тус Архивын ерөнхий газрын мэргэшүүлэх сургалтад хамруулсан.

2.4.Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2.5.9-д заасны дагуу ажилтан ажлаас чөлөөлөгдөхөд бичиг хэрэг, архивын ажилтан гишүүнээр ажиллаж цаасан болон цахим баримтыг актаар хүлээн авч хэвшээгүй.

2.5.Бичиг хэрэг, архивын ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны гэрэлтүүлгийн норматив, өрөө тасалгаа хэвийн нөхцөлтэй. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох техник хэрэгсэл, компьютер, сканнер, принтер бусад тоног төхөөрөмжөөр хангасан.

2.6.Шаардагдах техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн хүчин чадлыг сайжруулах программ хангамжийн зардлыг төсөвтөө тусгаж хэвшээгүй.

2.7.Баримт хүлээж авах төлөвлөгөө хуваарь батлуулж хэвшээгүй.

2.8.Байгууллагын архивын баримтыг төрөлжүүлж бүртгэл үйлдээгүй. Албан хаагчид архивт баримтаа бүрэн бүрдэлтэйгээр шилжүүлж хэвшээгүй байна.

2.9 Байгууллагын баримт нягтлан шалгах комиссыг томилж дүрмийг баталсан боловч үйл ажиллагаа нь тогтмолжоогүй.

2.10.Байнга, түр хадгалах баримтын данс, бүртгэл, устгах баримтын жагсаалтыг байгууллагын БНШК-ын хурлаар хэлэлцүүлж хэвшээгүй. Төрийн архивт сан хөмрөг үүсгэж нөхөн бүрдүүлэлт хийгдээгүй.

2.11.Архивын гэрчилгээ болон түүхчилсэн лавлахт баяжилт хийгдээгүй.

2.12.Байгууллагын архивын баримтад тооллого хийгдээгүй.

2.13.Хадгаламжийн нэгжийг журмын дагуу тавиур шүүгээнд зөв байрлуулаагүй, тавиур шүүгээг дугаарлаагүй, заагуур үйлдээгүй.

2.14.Архивын өрөөнд жилд 2 удаа эрүүл ахуй, ариутгал, халдваргүйжүүлэлт хийгдэж хэвшсэн.

2.15.Хадгаламжийн санд чийг дулаан хэмжигч байгаа боловч бүртгэл хөтөлж хэвшээгүй. Цэвэрлэгээ үйлчилгээний бүртгэл хөтөлж хэвшээгүй.

2.17.Архивын үйл ажиллагаанд ашиглах программ байхгүй ч удирдлагын баримт бичгийг цахимжуулсан.

2.18.Байгууллагын нийт ажилтны албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд архивын үйл ажиллагааны талаарх хүлээх үүргийг тусгаагүй.

2.19.Хадгаламжийн нэгжийг зориулалтын шүүгээнд байршуулаагүй, зориулалтын тэргэнцэр, тоос сорогч, агааржуулагч, камергүй, аврах гарцын схем, галын самбар байршуулаагүй.

2.20.2005 оноос хойш төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийж данс бүртгэлээ төрийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлж батлуулаагүй, баримтаа төрийн архивт шилжүүлээгүй.

2.21.Архив, бичиг хэргийн ажилтны компьютер вирусн лицензтэй программгүй.

2.22 Байгууллагын хэмжээнд нийт нэг сервер компьютер ажилладаг бөгөөд цаг бүртгэл, Цалин, хүний нөөцийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангуудын нөөцлөлт (back up) хийдэг. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмын нууц үгийг 8-аас дээш тэмдэгт орсон нууц үгийг үүсгэж ашигладаг.

Цаашид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1.Шаардагдах техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн хүчин чадлыг сайжруулах программ хангамжийн зардлыг төсөвтөө тусгаж хэвших;

2.Баримт хүлээж авах төлөвлөгөө хуваарь батлуулж хэвших;

3.Байгууллагын архивын баримтыг төрөлжүүлж бүртгэл үйлдэх. Албан хаагчид архивт баримтаа бүрэн бүрдэлтэйгээр шилжүүлж хэвших;

4.Байгууллагын баримт нягтлан шалгах комиссыг шинэчлэн томилж дүрмийг батлах. Баримт нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг тогтмолжуулах;

5.Байнга, түр хадгалах баримтын данс, бүртгэл, устгах баримтын жагсаалтыг байгууллагын БНШК-ын хурлаар хэлэлцүүлж хэвших. Төрийн архивт сан хөмрөг үүсгэж нөхөн бүрдүүлэлтийг хийж хөмрөг үүсгэж Архив, албан хэрэг хөтлөлтийнтухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах;

6.Архивын гэрчилгээ болон түүхчилсэн лавлахт баяжилт хийх;

7.Байгууллагын архивын баримтад тооллого хийж хэвших;

8.Хадгаламжийн нэгжийг журмын дагуу тавиур шүүгэнд зөв байрлуулж, тавиур шүүгээг дугаарлах, заагуур үйлдэх;

9.Хадгаламжийн сангийн чийг дулааныг тогтмол бүртгэж хэвших;

10.Байгууллагын нийт ажилтны албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд архивын үйл ажиллагааны талаарх хүлээх үүргийг тусгах;

11.Хадгаламжийн нэгжийг зориулалтын шүүгэнд байршуулах, зориулалтын тэргэнцэр, тоос сорогч, агааржуулагч, камергүй, аврах гарцын схем байршуулах;

12.Архив, бичиг хэргийн ажилтны компьютерыг вирусын лицензтэй програмаар хангах;

13. Архивын баримтыг цахимжуулах төлөвлөгөө гаргаж архивын программыг бүрэн ашиглаж хэвших;

14.2005 оноос хойшхи баримтаа төрийн архивт шилжүүлэх;

Гурав.Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын талаар

3.1 Байгууллагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн хүрээнд:

Байгууллагын стратеги төлөвлөгөөг МУ-н урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичигтэй уялдуулсан эсэх, журмын дагуу боловсруулсан эсэх, хуульд заасан цаглабарт хугацаанд, төлөвлөлтөд нийцүүлэн, үр дүнг тооцож, тайлганасан эсэх

Байгууллагын стратеги төлөвлөгөөг 2016 оноос хойш батлуулаагүй, одоо батлуулахаар стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь салбар, орон нутгийн стратеги төлөвлөгөөтэй уялдсан эсэх, журмын дагуу боловсруулсан эсэх, хуульд заасан цаглабарт хугацаанд төлөвлөлтөд нийцүүлэн, үр дүнг тооцож, тайлганасан эсэх

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3, 4 дүгээр хавсралтын дагуу “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, загвар”-ын дагуу 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилт 81,6%-тай үнэлэгдсэн байна.

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нийт 6 зорилтын хүрээнд 34 үйл ажиллагааг төлөвлөн, хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт гаргасан боловч үр дүнг тооцож, зөвлөгөө, зөвлөмж гаргаагүй, баталгаажилт хийгдээгүй байна.

Нэгжийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулсан эсэх, журмын дагуу боловсруулсан эсэх, хугацаанд нь төлөвлөлтөд нийцүүлэн, үр дүнг тооцож, тайлганаж, үнэлсэн эсэх, гарын үсэг зуруулж баталгаажуулсан эсэх

ЭСҮТ нь одоогоор 59 албан хаагчидтай ажиллаж байна. Албан хаагчдын төлөвлөгөө гэж гардаггүй харин албадын төлөвлөгөө, тайлан гардаг. Албадын төлөвлөгөөний биелэлтээр дүгнэгдэн албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг улирлаар олгодог байна.

Стратеги төлөвлөгөө, байгууллагын, болон харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ХБТтУТ хуулийн 6.10.2 дахь заалтад заасан шаардлагыг бүрэн хангасан эсэх

Байгууллагын стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа санхүүжилттэй арга хэмжээн дээр техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийгдээгүй, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн эсэх дээр үзүүлэх зүйл байхгүй, зарцуулалт нь ямар байгаа дээр дүгнэлт хийгдээгүй байна.

Байгууллагын болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг эсэх,

үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулсан эсэх, саналд үндэслэсэн хариу арга хэмжээ хэрэгжүүлсэн эсэх

Байгууллагын болон албад, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэггүй байна.

Байгууллагын чиг үүрэг, бүтэц орон тооны оновчтой байдлын хүрээнд:

Байгууллагын болон харьяа байгууллагын стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц орон тоог чиг үүргийн шинжилгээнд үндэслэн боловсруулсан эсэх

Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны “Эмгэг судлалын үндэсний төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” А/294 дүгээр тушаалын дагуу нийт 6 алба, 3 тасаг, 2 зөвлөлтэй үйл ажиллагаа явуулж байна. Одоо ЭМЯ дээр “Эмгэг судлалын үндэсний төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” тушаалын төслийг хянуулж байна.

Байгууллагын болон харьяа байгууллагын чиг үүргийн шинжилгээг Төсвийн тухай хуулийн 14.2.11 дэх заалтад заасан хугацаанд чиг үүрэг, үр дүнгийн шинжилгээ хийсэн эсэх

Байгууллагын чиг үүргийн шинжилгээг Төсвийн тухай хуулийн 14.2.11 дэх заалт "...өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах"-д гэж заасан хугацаанд чиг үүрэг, үр дүнгийн шинжилгээ хийгдээгүй болно.

Байгууллагын нэгжийн чиг үүргийг оновчтой хуваарилсан эсэх, түүнд нийцсэн орон тоог оновчтой тогтоож, ажлын байрны нэршлийг зөв, оновчтой тогтоосон эсэх

Байгууллагын нэгжийн чиг үүрэг Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/294 дүгээр тушаалын дагуу бүтэц дүрэм шинэчлэгдээгүй байгаа учир энэхүү асуудлын хүрээнд үзүүлэх зүйл байхгүй байна.

АТТ боловсруулахдаа ажлын байрны шинжилгээ хийсэн эсэх, шинжилгээнд үндэслэн чиг үүргийг хуваарилсан эсэх

АТТ боловсруулахдаа ажлын байрны шинжилгээ хийгүй байна. 2025 онд 32 АТТ шинэчлэн гаргасан ч дүн шинжилгээ хийгдээгүй байна.

Албан тушаалын ангилал зэрэглэлийг хууль, журмын дагуу зөв тогтоосон эсэх

МУ-ын Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 2, 6, 7 дугаар хавсралтын дагуу 2025.01.02 өдрийн А/01 тушаалын дагуу 70 орон тоогоор батлагдсан. 2025 оны 8 дугаар сарын төсвийн тодотголоор 64 орон тоотойгоор батлагдсан.

Байгууллагын бүтэц дэх удирдах, гүйцэтгэх төрөлд хамаарах орон тоо, үндсэн чиг үүрэг хэрэгжүүлэх орон тооны зохист харьцааг оновчтой тогтоосон эсэх /нийт орон тоонд эзлэх үндсэн чиг үүрэг хэрэгжүүлж буй албан тушаал 60 хувиас багагүй, удирдах албан тушаалын тоо 5 хувиас ихгүй байх

Эрүүл мэндийн сайдын 2025 оны “Эрүүл мэндийн байгууллагын 2025 оны тодотгосон төсөв” А/297 дугаар тушаалаар байгууллагын орон тоог багасгасан. Нийт 64 орон тоонд эзлэх үндсэн чиг үүрэг хэрэгжүүлж буй албан тушаалтны эзлэх хувь 67%, удирдах албан тушаалтны эзлэх хувь 9% байна.

3.2 Байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа

Төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийн үйл ажиллагааны хүрээнд:

Албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлсон эсэх, хэрэгцээнд үндэслэсэн сургалтын хөтөлбөр баталсан эсэх, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан эсэх, төсөв санхүүжилтийг тусгасан, хэрэгжилтийг дүгнэсэн эсэх

Нийт албан хаагчдын сургалтын хэрэгцээг аваагүй боловч сургалтын төлөвлөгөө сараар гарсан байна.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаж, удирдлагын хурлаар хэлэлцүүлсэн эсэх, дотоод хяналтын нэгж, ажилтан үнэлсэн эсэх, хэрэгжүүлэх санхүүжилтын эх үүсвэрийг төлөвлөгөөний дагуу шийдвэрлэсэн эсэх

Тухайн үед хийсэн сургалт болгоны дараа илтгэх хуудас бичдэг боловч удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дотоод хяналт хийдэггүй. Сургалттай холбогдолтой

санхүүжилт нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан, сургалт хэрхэн хийх талаар төсвийн задаргаа гаргаагүй байна. Сургалттай холбоотой санхүүгийн баримт бэлэн үзүүлэх зүйл байхгүй учир үнэлээгүй.

Албан хаагчдын сургалтад хамрагдсан байдал (нийт албан хаагчдын 80-аас дээш хувь хамрагдсан байх. Үүнээс үндсэн чиг үүргийн чиглэлээр гадаад, дотоодод мэргэшүүлэх давтан сургалтад хамрагдсан албан хаагчийн эзлэх хувь 60-аас доошгүй байх).

2025 онд дотоод сургалт 18 удаа хийгдсэнээс албан хаагчид давтагдсан тоогоор 470 хүн сургалтад хамрагдсан. Үндсэн чиг үүргийн чиглэлээр гадаад, дотоодод мэргэшүүлэх давтан сургалтад 23 албан хаагчид хамрагдсанаас гадаадад 6, дотоодод 17 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна.

Гадаад дотоодын давтан сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах (нийт давтан сургалтад хамрагдсан албан хаагчийн тоонд гэрээтэй суралцсан албан хаагчийн тоо, ажлын байраар хангагдсан албан хаагчийн тоо, байгууллагаас сургалтын зардлыг шийдвэрлэн сургасан албан хаагчийн тооны эзлэх хувиар тооцох)

2025 онд гэрээтэй, гадаадад суралцсан албан хаагчийн тоо 5 байгаагаас 2 эмч, мэргэжилтэн суралцахаар явсан. Харин 3 эмч, мэргэжилтэн нь төгсөж ирээд ажлын байран дээрээ ажиллаж байгаа. Гадаадад суралцахаар явж байгаа эмч, мэргэжилтэнд сарын цалинг байгууллагаас олгодог.

Төрийн албан хаагчийн мэргэшсэн тогтвортой байдалын хүрээнд:

Бүтэц, төсвийн тодотголоор 2025 онд 64 албан хаагч ажиллахаар баталсан. Одоо ажиллаж байгаа албан хаагчид 59 байна.

МУ-ыг Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолын 2, 6, 7 дугаар хавсралтын дагуу 2025.01.02-ны өдрийн А/01 дугаар тушаалын дагуу 70 орон тоогоор батлагдсан. Харин 8 дугаар сард төсвийн тодотголоор 64 орон тоотой болгосон.

Хүний нөөцийн томилгоо чөлөөлөлт, нөөц бүрдүүлэлт, ёс зүй, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд:

2025 онд 18 албан хаагчийг шинээр ажилд авч, 17 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн. Чөлөөлөгдсөн албан хаагчийн 90 орчим хувь нь өөрсдийн хүсэлтээр байсан.

УИХ-ын 2023 оны "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хууль, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын дагуу Ёс зүйн дэд хороо байгуулагдаагүй байна.

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2022 оны 491 дүгээр тогтоолын дагуу албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгодог. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл авч буй 45 албан хаагч байна.

Нийт албан хаагчдын дунд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа болох дархлаажуулалт, эрүүл мэндийн зарим үзүүлэлтүүдийг үзэх шинжилгээнүүд хамруулсан. Одоогоор нийт албан хаагчдад урьдчилан сэргийлэх үзлэг хийгдээгүй байна.

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөн

Хувийн хэргийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтын хүрээнд:

Байгууллагын албан хаагчид өөрийн хувийн хэргийн цахим сангийн мэдээлэлтэй танилцаж, баталгаажуулалт хийдэггүй байна.

"ХНУМТ" цахим системийн мэдээллийн сангийн хөтлөлт, бүрдлийн хүрээнд:

Цахим системд одоо ажиллаж байгаа идэвхтэй 59 албан хаагчийн бүртгэл байна. Порталд албан хаагчид хандалт хийгдээгүй, системээс мэдээллийн лавлагаа гаргаж өгсөн тухай бүртгэл хөтөлж, хадгалдаг эсэх, төрийн албан хаагчийн мэдээлэлд дүн шинжилгээ, боловсруулалт хийдэг эсэх мэдээлэл байхгүй. Мөн албан хаагчдын нэгдсэн тоо бүртгэл, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хугацаанд нь үнэн зөв гаргасан эсэх, удирдлага баталгаажуулан архивын баримт үүсгэсэн эсэхэд мэдээлэл байхгүй байна.

Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, шатлан дэвшүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн

Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилтийн хүрээнд:

ЭСҮТ-ийн захирлын 2025.05.21 өдрийн А/31 дугаар тушаалаар "Ажилтан сонгон шалгаруулах, ажилд авах тухай" журмын дагуу сул орон тоонд сонгон шалгаруулалт хийж албан хаагчдыг ажилд авдаг байна.

Цаашид авах арга хэмжээ:

1.Төрийн албаны тухай хуулийн 53.1 дэх хэсэг "Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна." гэж заасны дагуу Эрүүл мэндийн сайдаар байгууллагын стратеги төлөвлөгөөг батлуулах;

2.Байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг журмын дагуу үр дүнг тооцож, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийн, баталгаажуулж байх;

3.Стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ХБТтУТ хуулийн 6.10.2 дахь заалт "санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх"-ын дагуу боловсруулах;

4.Ажлын байрны дүн шинжилгээнд үндэслэн байгууллагын бүтэц, чиг үүргийг хуваарилах;

5.Албан хаагчдын АТТ боловсруулахдаа ажлын байрны шинжилгээ хийх, дүн шинжилгээнд үндэслэн чиг үүргийг хуваарилах;

6.Байгууллагын албан хаагчдын дотоодын сургалтын хэрэгцээг тодорхойлон, сургалтын хөтөлбөр гарган, төлөвлөгөө боловсруулж, санхүүжилтийг тусган, хэрэгжилтийг дотоодын хяналтын нэгж, ажилтанаар үнэлүүлэх;

7.Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын дагуу Ёс зүйн дэд хороо байгуулах;

8."ХНУМТ" цахим системийн мэдээллийн сангийн хөтлөлтийг бүрэн, гүйцэт бөглөн, системийн баяжилтыг хийх;

9.Байгууллагын албан хаагчдын дунд урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулж, албан хаагчдыг үзлэгт бүрэн хамруулах;

10.Тухайн онд шилжилт, хөдөлгөөн хийсэн албан хаагчдын тоо байгууллагын нийт албан хаагчдын 25 хувиас хэтэрсэн байна. Байгууллагын шилжилт, хөдөлгөөнд анхаарах;

Дүгнэлт:

Эмгэг судлалын үндэсний төв нь улсын үзлэгт дараах дүнтэй дүгнэгдэв. Үүнд:

- 1.Албан хэрэг хөтлөлт 80.5 хувь буюу "В" үнэлгээ (хавсралт 1)
- 2.Байгууллагын архивын үйл ажиллагаа 80 хувь буюу "В" үнэлгээ (хавсралт2)
- 3.Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт 72.2 хувь буюу "С" үнэлгээ (хавсралт3)

Нэгдсэн дүн:77.5 хувь буюу "С" үнэлгээ авсан.

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ

УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА *С.Эрдэнэтуяа* С.ЭРДЭНЭТУЯА

ГИШҮҮД:

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН

ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН *Б.Оролзодмаа* Б.ОРОЛЗОДМАА

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН

БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ *Б.Амгаланзаяа* Б.АМГАЛАНЗАЯА

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН

АРХИВЫН ЭРХЛЭГЧ *Р.Мөнхбаяр* Р.МӨНХБАЯР



АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ, АРГАЧЛАЛ

2025 оны 10 дугаар сарын 07 (огноо) судлаачийн үндэсний хэрэгжлтийн дүгнэлт (байгууллагын нэр) Улаанбаатар хот (оршин буй газрын нэр)

Д/д	Үндсэн үзүүлэлт	Дүгнэх шалгуур	Тус бүрт өгөх оноо			Ерөнхий оноо	Үндэслэл болгох, хууль тогтоомж, эрх зүйн актын заалт
			Авбал зохиох	Авсан	7		
1	2 Албан хэрэг хөтлөлтийн талаар байгууллага, удирдлага, ажилтнуудын хүлээх үүрэг түүний хэрэгжилт	3 Албан хэрэг хөтлөлтийн талаар байгууллагын удирдлагын хүлээх үүрэг, түүний хэрэгжилт Албан хэрэг хөтлөлтийн талаар нэгжийн удирдлагын хүлээх үүрэг, түүний хэрэгжилт Бичиг хэргийн ажилтны багцадсан орон тооны ажилтантай эсэх, ажилтны чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод оновчтой тусгасан байдал Байгууллагын ажилтнуудын албан хэрэг хөтлөлтийн талаарх хүлээх үүргийг албан тушаалын тодорхойлолтод, дотоод журамд тусгаж, түүний хэрэгжилтийг гүйцэтгэлийн төлөвлөгөө болон	4 20	5 10	6 20	Төсвийн тухай хуулийн 16.4, 16.5.3, 16.5.5, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5.4, 5.5, 24, 35.1, 35.2 Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын (цаашид "АХХНЖ" гэх) 2.2, 2.3, 6.1, 8.1.7, 8.1.13, Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага MNS 5140-2:2021 стандартын 5.24 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35.3 АХХНЖ-ын 2.3.3, Архивын ерөнхий газрын даргын 2015 оны А/131 дүгээр тушаалаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтны хөдөлмөрийн норм, норматив"-ын 3.2 Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам" АХХНЖ-ын 1.7, 2.2.9, 2.3.3, 2.4, 2.5, 2.6, 4.18, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн	

	<p>хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ харгалздаг эсэх</p>				<p>төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, ҮР дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам" Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 1, 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал" АХХНЖ-ын 2.4.6, 2.5.9,</p>
<p>Ажилтан ажлаас чөлөөлөгдөх, өөрчлөгдөх, эзлжийн амралт, урт хугацааны чөлөө авсан тохиолдолд хөтлөгдөж буй албан хэргээ журмын дагуу хүлээлцсэн байдал (албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан гишүүнээр ажилласан)</p>	20		10	<p>Төрийн албаны тухай хуулийн 77.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 5-р хавсралт Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол (8-р хавсралт) Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2020 оны хамтарсан А/62 / 78 / А/89 тоот тушаалаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт"-ын 1.1. 1.2, 1.3</p>	
<p>Бичиг хэргийн ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг хангах талаар холбогдох арга хэмжээ авсан эсэх</p>	20		20	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөх дээд хэмжээ. MNS 4990:2023 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5080:2023 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага. MNS 6767:2019 АХХНЖ-ын 2.2.2, 2.2.6, 2.3.3, Архивын ерөнхий газрын даргын 2015 оны А/131 дүгээр тушаалаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтны Хөдөлмөрийн үлгэрчилсэн норм, норматив" 1.1.1, 1.1.2, 1.1.3, 1.1.4, 1.2.1</p>	
<p>Бичиг хэргийн ажилтны хөдөлмөр зохион байгуулалт, ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа шаардлага хангасан эсэх</p>	20		20		

	Бичиг хэргийн ажилтныг албан хэрэг хөтлөлтийн талаар сургаж мэргэшүүлэх, чадавхжуулах талаар удирдлагаас тодорхой арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн байдал	20		Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2020 оны хамтарсан А/62 / 78 / А/89 тоот тушаалаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт"-ын 1.1, 1.2, 1.3 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 3 дахь хэсэг, АХХНЖ-ын 2.2.8,
